



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
АНАГААХ УХААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН
ХОРООНЫ ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 26/001

Улаанбаатар хот

「Судалгааг эхлүүлэх зөвшөөрөл олгох тухай」

Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 26/01 дүгээр хурлын протоколыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол хүүхдийн хоол хүнсний сонголт, хооллолтод эрүүл бус хүнсний маркетингийн нөлөө: Хүүхдийг хамгаалахад чиглэсэн хүнсний маркетингийн бодлогыг бэхжүүлэх талаар оролцогч талуудын үзэл бодол” сэдэвт Монгол Улсын Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв болон Австрали Улсын Воллонгонг их сургуулийн хамтарсан судалгааны төслийг судлаач, Анагаах ухааны доктор, Bridget Kelly, Chris Degeling нарын удирдлаган дор 2026-2027 онд багтаан хэрэгжүүлж, гүйцэтгэхийг зөвшөөрсүгэй.

2. Судалгааны явцад тодорхой шалтгааны улмаас арга аргачлал өөрчлөгдөх, гадаад орон руу сорьц тээвэрлэх, Хельсинкийн тунхаглалд туссан ёс зүйн асуудал хөндөгдсөн тохиолдолд Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд мэдэгдэж, дахин хэлэлцүүлэхийг судалгааны удирдагч нар болон багийнханд үүрэг болгосугай.

3. Судалгааны явцын тайланг Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд ирүүлэхийг төслийн удирдагч нарт үүрэг болгосугай.

4. Судалгааны төгсгөлийн тайланг Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, судалгаа дууссан хугацаанаас хойш 2 сарын дотор багтаан Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд ирүүлэхийг төслийн удирдагч нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.МӨНХЦЭЦЭГ

